



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 08 сарын 30 өдөр

Дугаар 5/8Н

Хэрлэн сум

М.Гантигмааг үргэлжлүүлэн ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3 дахь заалт, 139 дүгээр зүйлийн 139.2 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 240 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт, 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 128 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам", Засгийн газрын 2024 оны "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох тухай" 82 дугаар тогтоолын хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор Залуучуудын хөгжлийн төвийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэд ажиллуулах шийдвэр гарсантай холбогдуулан Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын Залуучуудын хөгжил, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа хариуцсан ажилтнаар ажиллаж байсан Мөнгөнцогийн Гантигмаа нь хүүхэс асрах чөлөө дуусаж, үүрэгт ажилдаа эргэн орох хүсэлт гаргасан тул 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн үргэлжлүүлэн ажиллуулсугай.

2. М.Гантигмаагийн ажлыг хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.


Комиссын дарга:	Н.Зоригтбаатар	Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Гишүүд:	Э.Сувд-Эрдэнэ	Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн
	Т.Баяртуяа	Нярав

3. М.Гантигмаагийн үндсэн цалинг ТҮ-7 зэрэглэлээр тогтоон, 1264000 (нэг сая хоёр зуун жаран дөрвөн мянга) төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 4 хувиар, орон нутагт ажилласны нэмэгдлийг 40 хувиар тус тус тооцож, олгохыг нягтлан бодогч (Г.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

4. М.Гантигмаагийн ажлыг зохих хууль, журмын дагуу хүлээлцүүлэхийг ажил хүлээлцүүлэх комисс (Н.Зоригтбаатар)-д даалгасугай.

5. Холбогдох хууль тогтоомжид заагдсан чиг үүрэг болон хөдөлмөрийн гэрээ, дүрэм журмыг хэрэгжүүлж ажиллахыг М.Гантигмаад үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА

D:\My Documents\ Тушаал-2024

231030316